

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/145-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a> Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayaro@audit.gov.mn">ankhbayaro@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Албан шаардлага .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II бар  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

*2023-02-25* / *СА-2023/145-НАСТАНД*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ  
СУМЫН НИЙТИЙН НОМЫН  
САНГИЙН ЗАХИРАЛ А.ОЮУНСҮРЭН  
ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан, төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн зөрчлүүдийг давтан гаргасан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Татварын ерөнхий хуулийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлын ангиллын тайлбар болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Мандал сумын Нийтийн номын сангийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 10.3 хувиар хэмнэсэн байна.

Дээд шатны төсвөөс 4,750.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт шилжиж ирсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Мандал сумын Нийтийн номын сангийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 69.4 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн, 7.3 хувийг хангамж, бараа материалын, 5.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол, 4.3 хувийг бараа үйлчилгээний бусад, 5.8 хувийг бусад урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэлж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,519,075.00</b>	<b>30,299,988.14</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>17,704,413.14</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>17,704,413.14</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>0.00</b>	<b>17,704,413.14</b>
31211	Төрийн сангийн харилцах	0.00	17,704,413.14
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>3,519,075.00</b>	<b>12,595,575.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>0.00</b>	<b>250,000.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	0.00	250,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>3,519,075.00</b>	<b>12,345,575.00</b>
35410	Бичиг хэргийн материал	465,500.00	75,000.00
35420	Аж ахуйн материал	1,810,900.00	1,797,900.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	9,305,000.00
35450	Барилгын засварын материал	334,500.00	259,500.00
35470	Бусад хангамжийн материал	908,175.00	908,175.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>273,532,842.36</b>	<b>276,398,408.16</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>273,532,842.36</b>	<b>276,398,408.16</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>251,232,842.36</b>	<b>254,098,408.16</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	114,845,517.35	114,845,517.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,522,442.50	-8,436,534.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,400,000.00	21,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,400,000.00	-21,400,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	8,360,807.70	8,360,807.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,595,590.46	-8,265,906.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,208,061.95	7,208,061.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,379,851.45	-5,894,467.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	55,133,727.33	55,133,727.33
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,784,709.76	-7,569,419.52
39217	Ном	88,967,322.20	98,716,622.20
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>22,300,000.00</b>	<b>22,300,000.00</b>
39301	Программ хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	22,300,000.00	22,300,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>277,051,917.36</b>	<b>306,698,396.30</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>277,051,917.36</b>	<b>306,698,396.30</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>277,051,917.36</b>	<b>306,698,396.30</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	105,164,201.70	105,164,201.70
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	105,164,201.70	105,164,201.70
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>42,698,720.91</b>	<b>72,345,199.85</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	46,056,745.53	-234,353,196.45
51220	Тайлант үеийн үр дүн	-3,358,024.62	306,698,396.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	129,188,994.75	129,188,994.75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>277,051,917.36</b>	<b>306,698,396.30</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>133,921,175.24</b>	<b>468,451,117.36</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>444,600.00</b>	<b>277,051,917.36</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>444,600.00</b>	<b>277,051,917.36</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	444,600.00	273,532,842.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	3,519,075.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>133,476,575.24</b>	<b>218,514,910.30</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>0.00</b>	<b>191,399,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	191,399,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>133,476,575.24</b>	<b>27,115,710.30</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	133,476,575.24	27,115,710.30
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>137,279,199.86</b>	<b>188,868,431.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>137,279,199.86</b>	<b>188,868,431.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>136,862,499.86</b>	<b>159,745,031.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>103,394,955.49</b>	<b>106,915,285.54</b>
210101	Үндсэн цалин	75,262,162.38	81,058,080.98
210102	Нэмэгдэл	28,132,793.11	19,232,420.69
210104	Урамшуулал	0.00	6,624,783.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,590,208.33</b>	<b>13,651,743.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	9,108,572.90	9,509,751.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,686,147.67	1,115,794.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	754,561.66	854,715.36
210204	Ажилгүйдлийн даатгал	178,804.55	187,292.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,862,121.55	1,984,189.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,865,781.06</b>	<b>9,472,384.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	452,135.19	585,629.18
210302	Түлш, халаалт	6,815,300.86	7,963,065.78
210303	Цэвэр, бохир ус	598,345.01	923,689.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>2,893,535.54</b>	<b>3,400,184.00</b>
210401	Бичиг хэрэг	1,471,900.00	1,730,282.00
210402	Тээвэр, шатахуун	253,000.00	406,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,168,635.54	1,250,502.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	13,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>523,000.00</b>	<b>400,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>388,000.00</b>	<b>8,038,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	375,000.00	1,250,000.00
210604	Урсгал засвар	13,000.00	6,788,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>403,700.00</b>	<b>500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	403,700.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>224,700.00</b>	<b>10,088,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	10,088,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	156,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,578,619.44</b>	<b>7,278,734.20</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	395,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,578,619.44	6,883,734.20
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>416,700.00</b>	<b>29,123,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>416,700.00</b>	<b>29,123,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	28,355,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	768,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-3,358,024.62</b>	<b>306,698,363.30</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-3,358,024.62</b>	<b>306,698,363.30</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>133,476,575.24</b>	<b>218,514,910.30</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>4,750,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>4,750,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>4,750,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4,750,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>133,476,575.24</b>	<b>218,514,910.30</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>0.00</b>	<b>186,649,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	186,649,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>133,476,575.24</b>	<b>27,115,710.30</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	133,476,575.24	27,115,710.30
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>129,147,575.24</b>	<b>200,810,497.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>129,147,575.24</b>	<b>200,810,497.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>128,730,875.24</b>	<b>171,687,097.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>103,323,310.49</b>	<b>106,915,285.54</b>
210101	Үндсэн цалин	75,190,517.38	81,058,080.98
210102	Нэмэгдэл	28,132,793.11	19,232,420.69
210104	Урамшуулал	0.00	6,624,783.87
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,997,848.15</b>	<b>13,651,743.04</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,516,212.72	9,509,751.83
210202	Тэтгэмжийн даатгал	1,686,147.67	1,115,794.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	754,561.66	854,715.36
210204	Ажилгүйдлийн даатгал	178,804.55	187,292.11
210205	Эрүүл мэндийн даатгал	1,862,121.55	1,984,189.50
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>7,865,781.06</b>	<b>9,472,384.58</b>
210301	Гэрэл, цахилгаан	452,135.19	585,629.18
210302	Түлш, халаалт	6,815,300.86	7,963,065.78
210303	Цэвэр, бохир ус	598,345.01	923,689.62
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,017,535.54</b>	<b>2,996,684.00</b>
210401	Бичиг хэрэг	1,595,900.00	1,339,782.00
210402	Тээвэр, шатахуун	253,000.00	406,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,168,635.54	1,250,502.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>375,000.00</b>	<b>8,213,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	375,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	0	6,713,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>403,700.00</b>	<b>500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	403,700.00	500,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>347,700.00</b>	<b>12,288,200.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,000.00	12,288,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	156,700.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>7,500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	7,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>416,700.00</b>	<b>29,123,400.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>416,700.00</b>	<b>29,123,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	28,355,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	768,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>4,329,000.00</b>	<b>27,453,713.14</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>4,329,000.00</b>	<b>9,749,300.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,329,000.00</b>	<b>9,749,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>4,329,000.00</b>	<b>9,749,300.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,329,000.00	9,749,300.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-4,329,000.00</b>	<b>-9,749,300.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>17,704,413.14</b>
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	17,704,413.14

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	46,056,745.53	280,409,941.98
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	46,056,745.53	280,409,941.98
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,358,024.62	-3,358,024.62
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	42,698,720.91	277,051,917.36
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	42,698,720.91	277,051,917.36
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-277,051,917.36	-277,051,917.36
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	-234,353,196.45	-234,353,196.45
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	306,698,396.30	306,698,396.30
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	105,164,201.70	129,188,994.75	72,345,199.85	306,698,396.30

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>223,906,300.00</b>	<b>200,810,497.16</b>	<b>-23,095,802.84</b>	<b>89.69</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>223,906,300.00</b>	<b>200,810,497.16</b>	<b>-23,095,802.84</b>	<b>89.69</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>194,782,900.00</b>	<b>171,687,097.16</b>	<b>-23,095,802.84</b>	<b>88.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>122,879,700.00</b>	<b>106,915,285.54</b>	<b>-15,964,414.46</b>	<b>87.01</b>
210101	Үндсэн цалин	91,848,300.00	81,058,080.98	-10,790,219.02	88.25
210102	Нэмэгдэл	20,086,600.00	19,232,420.69	-854,179.31	95.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,804,000.00	0	-6,804,000.00	0.00
210104	Урамшуулал	4,140,800.00	6,624,783.87	2,483,983.87	159.99
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>15,360,100.00</b>	<b>13,651,743.04</b>	<b>-1,708,356.96</b>	<b>88.88</b>
210201	Тэтгэврийн даатгал	10,320,400.00	9,509,751.83	-810,648.17	92.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,240,500.00	1,115,794.24	-124,705.76	89.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,027,400.00	854,715.36	-172,684.64	83.19
210204	Ажилгүйдлийн даатгал	252,000.00	187,292.11	-64,707.89	74.32
210205	Эрүүл мэндийн даатгал	2,519,800.00	1,984,189.50	-535,610.50	78.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,673,700.00</b>	<b>9,472,384.58</b>	<b>-201,315.42</b>	<b>97.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	784,100.00	585,629.18	-198,470.82	74.69
210302	Түлш, халаалт	7,788,900.00	7,963,065.78	174,165.78	102.24
210303	Цэвэр, бохир ус	1,100,700.00	923,689.62	-177,010.38	83.92
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,767,600.00</b>	<b>12,745,984.00</b>	<b>-21,616.00</b>	<b>99.83</b>
210401	Бичиг хэрэг	1,340,400.00	1,339,782.00	-618.00	99.95
210402	Тээвэр, шатахуун	552,000.00	406,400.00	-145,600.00	73.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,125,200.00	1,250,502.00	125,302.00	111.14
210404	Ном, хэвлэл	9,750,000.00	9,749,300.00	-700.00	99.99
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	400,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,403,500.00</b>	<b>8,213,500.00</b>	<b>-190,000.00</b>	<b>97.74</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	6,903,500.00	6,713,500.00	-190,000.00	97.25
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,298,300.00</b>	<b>12,288,200.00</b>	<b>-10,100.00</b>	<b>99.92</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,298,300.00	12,288,200.00	-10,100.00	99.92
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,500,000.00</b>	<b>7,500,000.00</b>	<b>-5,000,000.00</b>	<b>60.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500,000.00	7,500,000.00	-5,000,000.00	60.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>29,123,400.00</b>	<b>29,123,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>29,123,400.00</b>	<b>29,123,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,355,400.00	28,355,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>223,906,300.00</b>	<b>218,514,910.30</b>	<b>-5,391,389.70</b>	<b>97.59</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>186,649,200.00</b>	<b>186,649,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	186,649,200.00	186,649,200.00	0.00	100.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>27,507,100.00</b>	<b>27,115,710.30</b>	<b>-391,389.70</b>	<b>98.58</b>
320001	Орон нутгийн төсвөөс	27,507,100.00	27,115,710.30	-391,389.70	98.58
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>9,750,000.00</b>	<b>4,750,000.00</b>	<b>-5,000,000.00</b>	<b>48.72</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	0	-5,000,000.00	0.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,750,000.00	4,750,000.00	0.00	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	17,704,413.14	17,704,413.14	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>19</b>	<b>19</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>9</b>	<b>9</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	9	9	0.00	100.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нийтийн номын сан / цаашид *Нийтийн номын сан гэх*/ нь “Номын сан-соёлын үйлчилгээг хөгжүүлэн, иргэдэд мэдээлэл хүргэж мэдлэгийг дэмжин, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэн, уншигч хэрэглэгчдээ дээдлэн ажиллах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Стандартад нийцсэн орчин нөхцөлд зохих үйлчилгээг уншигчид үзүүлэх,
- Уншигчид уншлагын үйлчилгээг зохих журмын дагуу хүргэх,
- Номын сангийн сан хөмрөгийн бүрэн бүтэн байдлыг хангах,
- Номын сангийн сан хөмрөгийн эргэлтэд байнга судалгаа хийж, бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах арга хэмжээг тогтмол зохион байгуулах,
- Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах судар болон хуучин ном, гар бичмэлийг сурвалжлан олох, нөхөн бүрдүүлэх, олон нийтэд сурталчлах, хадгалах, хамгаалах хэвийн нөхцөлийг хангаж ажиллах,
- Номын сан, ном зүйн мэдээллийг автоматжуулах, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, цахим мэдээллийн санг бий болгох,

- Номын сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад үнэн зөв гаргаж өгөх,
- Дотоод, гадаадын номын сан, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Нийтийн номын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохироогүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,646.5 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	17,704.4	17,704.4
Бараа материал	3,519.1	12,595.6	9,076.5
Үндсэн хөрөнгө	273,532.8	276,398.4	2,865.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>277,051.9</b>	<b>306,698.4</b>	<b>29,646.5</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	277,051.9	306,698.4	29,646.5
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>277,051.9</b>	<b>306,698.4</b>	<b>29,646.5</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 17,704.4 мянган төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүждэг болсноос шалтгаалан төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,595.6 мянган төгрөг болж 9,076.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 26,884.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 17,808.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 328,214.7 мянган төгрөг болж 9,749.3 мянган төгрөгөөр өссөн нь 9,749.3 мянган төгрөгийн ном худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 306,698.4 мянган төгрөг болж 29,646.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 176,343.1 мянган төгрөг, нийт зарлагыг 176,343.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 19,794.4 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,057.5 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 5,468.5 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 11,348.4 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 768.0 мянган төгрөгөөр зэрэг **39,436.8** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,549.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 231.3 мянган төгрөгөөр,
- Томиллолт, зочны зардлыг 316.0 мянган төгрөгөөр зэрэг **2,096.3** мянган төгрөгөөр бууруулж, нийт **213,713.6** мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 10,192.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн *Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 596.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 4,750.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 180.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,500.0 мянган төгрөгөөр г.м/* төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 186,649.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 27,507.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 4,750.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны / нэмэлт санхүүжилтийн / орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 186,649.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 27,115.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоор 4,750.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 200,810.5 мянган төгрөг буюу 89.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого 5,000.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна.

## Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	147,525.8	129,821.4	17,704.4	88.0
2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	10,000.0	10,000.0	0.0	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	29,123.4	29,123.4	0.0	100.0
4	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	9,750.0	4,750.0	5,000.0	48.7
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	16,577.2	16,185.9	391.3	97.6
6	Нийтлэг үйлчилгээ	10,929.9	10,929.8	0.1	99.9
	<b>Дүн</b>	<b>223,906.3</b>	<b>200,810.5</b>	<b>23,095.8</b>	<b>89.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нийтийн номын сан нь нэмэлт санхүүжилтийн дансгүй бөгөөд тайлант оноос эхлэн урсгал зардлын 100130435022 тоот дансаар нэмэлт болон дээд шатны хуваарилсан орлогыг авч зарцуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийтийн номын сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийтийн номын сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 133,476.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **1,334.7** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийтийн номын сан нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлсэн,
- Гар утасны, хэвлэл захиалгын зардлуудыг гаргалгүй хэмнэж ажилласан,
- Сургалт, семинар, хурлыг цахимаар хийж байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Нийтийн номын сан нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 163 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

#### Хугацаа хоцроосон:

- Байгууллагын батлагдсан төсвийг 1 удаа,
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 1 удаа,

#### Огт мэдээлээгүй:

- Санхүүгийн тайланг 1 удаа
- Худалдан авах ажиллагааны тайланг 1 удаа

**Шийдвэрлэлт:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.10 дахь заалтуудыг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 203.0 мянган төгрөгийн, 272.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 2 зөрчилд зөвлөмж өгснийг тус тус хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	475.7			-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>475.7</b>			-

Өмнөх онд өгөгдсөн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан болон бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төсвийн шууд захирагчийн бус Сангийн яамны өгсөн чиглэлээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар, өөрөөр хэлбэл өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалснаар тайлагнагдаж байна.

Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт шилжүүлсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр эх үүсвэр хэлбэрээр төлөвлөж, зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **14,749.3** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 9,749.3 мянган төгрөгийн зардлыг урсгал зардлаар тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 5,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг дутуу тайлагнасан,

Аудитаар нийт 3,418.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас багаж, техник хэрэгслийн зардалд **2,200.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.
- Төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтаар баталгаажуулаагүй **903.8** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн батлагдсан төсвөөс **315.0** мянган төгрөгийн үнэ бүхий зориулалтын бус / дүрэмт болон ажлын тусгай зориулалтын бус / цамц худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлын ангиллын тайлбарт “Хуулийн дагуу тусгай дүрэмт хувцас хэрэглэх эрх бүхий албан хаагчдын дүрэмт хувцас болон ажлын тусгай зориулалтын нормын хувцас худалдан авах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг урсгал зардлаар тайлагнасан	1	9,749.3			1	9,749.3	1	9,749.3				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан	1	5,000.0			1	5,000.0	1	5,000.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>14,749.3</b>			<b>2</b>	<b>14,749.3</b>	<b>2</b>	<b>14,749.3</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	315.0			1	315.0						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй давтан гаргасан	2	3,103.8			2	3,103.8						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>3,418.8</b>			<b>3</b>	<b>3,418.8</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	2						2	
Огт мэдээлээгүй	2						2	
Дүн	4						4	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	4						4	